

БАРААНЫ ҮНИЙН САНАЛ АВАХ ХҮСЭЛТ (БҮСАХ)

Төслийн нэр: Зээл 4052-MON: Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2

Санхүүжилтийн эх үүсвэр: Азийн хөгжлийн банк

Гэрээний нэр: Программ хангамжийн лиценз нийлүүлэх

Дугаар: G002

Хүсэлтийг гаргасан огноо: 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Хэнд: Эрх бүхий оролцогчдод

Эрхэм хүндэт

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй “Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2” нь танай байгууллагаас буюу эрх бүхий оролцогчдоос программ хангамжийн лиценз нийлүүлэх тухай доорх нэр төрлийн бүх бараанд үнийн санал ирүүлэхийг хүсэж байна.

Но.	Барааны нэршил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Дотоод сүлжээний төхөөрөмжүүдийг хянах, сүлжээний ачааллыг зохицуулах программ хангамж	ширхэг	1
2	Халамжийн нэгдсэн систем (ehalamj)-ийн хэрэглэгчид рүү автоматаар мэдэгдэл илгээх програм хангамж	жил	3
3	Бизнесийн ухаалаг системийн программ хангамжийн лиценз	багц	1
4	Microsoft 365 Business Standard эсхүл дүйцэх	багц	1
5	Microsoft defender for endpoint эсхүл дүйцэх	багц	1
	Нийт		7

Танд үнийн санал бэлтгэхэд туслах зорилгоор бид шаардагдах Нийлүүлэлтийн хуваарь, Техникийн тодорхойлолт, Саналын маягт болон Гэрээний төслийн тухай мэдээллийг хавсаргав.

2. Хэрэв та/танай компани дараах нөхцөлүүдээс аль нэгийг нь хангаж байгаа бол таны саналаас татгалзана. Үүнд:

- (i) Та/танай компани АХБ-ны гишүүн орон болон түүний иргэний харьяалалгүй; эсвэл
- (ii) Та/танай компани зураг төсөл, техникийн тодорхойлолтыг бэлтгэсэн компанитай холбоотой, эсвэл энэхүү худалдан авалтын хүсэлтэд хамаарах гэрээний төсөл бэлтгэхэд хамтран оролцож байгаа бол; эсвэл
- (iii) та/танай компани захиалагчийн өмчлөлд хамаатай бол; эсвэл
- (iv) та/танай компани АХБ-ны авлигын эсрэг бодлогыг (1998 оноос одоог хүртэл нэмэлт өөрчлөлт оруулсан) зөрчсөн эсвэл одоогоор түр түдгэлзүүлсэн байгаа бол; эсвэл
- (v) НҮБ-ын дүрмийн 7-р бүлэгт заасан НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн дагуу танай улсаас бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ импортлох,

танай улсад байгаа этгээд, аж ахуйн нэгжид аливаа төлбөр төлөхийг хориглосон бол таны саналаас татгалзана.

3. Шаардлага хангасан байхын тулд, та шаардлагуудыг хангасан байх ёстой бөгөөд холбогдох нотлох баримт бичгүүдийг хавсралтаар ирүүлэх шаардлагатай. Үүнд:

- (i) 2023, 2024 онуудад үндсэн гүйцэтгэгчээр амжилттай ажиллаж дуусгасан 1 ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээтэй байна. Гэрээний үнийн хэмжээ 224,127,865.60 төгрөгөөс доошгүй байна. Гэрээний дагуу барааг хүлээлгэн өгсөн буюу ажил хүлээлцсэн актыг гэрээний хуулбарыг хамт ирүүлнэ. Ижил төстэй бараа гэдгийг программ хангамжийн лиценз гэж ойлгоно.

4. Та үнийн саналыг дараах заавар, журам, гэрээний хугацаа, нөхцөлийн дагуу ирүүлнэ.

Үнийн саналыг бэлтгэх

- (i) Та үнийн саналыг бүх барааны төрөлд ирүүлэх бөгөөд баримт бичгийн хавсралтын дагуу Үнийн саналын маягт, үнийг багтаасан Үнийн хуваарь ба Нийлүүлэлтийн хуваарийг хавсарган ирүүлнэ. Үнийн санал ба төлбөрийн валют нь төгрөгөөр илэрхийлэгдэнэ.
- (ii) Нийлүүлэлтийн хуваарьт буй эцсийн цэгт хүргэх зардлыг /Нийлүүлэлтийн хуваарь заасан газарт/ үнийг саналд багтаан ирүүлэх бөгөөд санал болгож буй бараа тус бүрд зохих техникийн баримт, каталогууд, бусад хэвлэмэл материал эсвэл холбогдох мэдээлэл, түүнчлэн Монгол улсад борлуулалтын дараах үйлчилгээ үзүүлэх компанийн нэр ба хаяг зэргийг Монгол хэл дээр үйлдэн хавсаргаж өгнө.
- (iii) Та дээрх нэршил бүхий бараанд зөвхөн нэг үнийн санал ирүүлнэ. Та саналаа шивсэн эсвэл арилдаггүй бэхээр бичих ёстой бөгөөд та эсвэл таны эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулна. Таны саналын маягт гарын үсэггүй тохиолдолд, таны саналыг цаашид үнэлгээнд харгалзан үзэхгүй.
- (iv) Та үнийн саналын нэг эх хувийг саналын маягттай ирүүлэх бөгөөд түүнд “Эх хувь” гэж тодорхой тэмдэглэн бичнэ. Үүнээс гадна, та түүнчлэн нэг хувийг “Хуулбар хувь” гэсэн бичиглэлтэйгээр ирүүлнэ. Эх хувь ба хуулбар хувь хоорондоо зөрүүтэй тохиолдолд эх хувийг дагаж мөрдөнө.
- (v) Таны үнийн санал доор дурдсан санал ирүүлэх эцсийн хугацаанаас хойш 45 хоногийн туршид хүчинтэй байх болно. Хэрэв та тендерийн хүчинтэй хугацаанд өөрийн саналаа буцааж авах ба/эсвэл гэрээний эрх олгогдсон байхад гэрээний эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал таныг 2 жилийн хугацаанд тухайн төслийн нийлүүлэгчдийн жагсаалтаас хасна.

Үнийн саналыг ирүүлэх, нээх

- (vi) Та Үнийн ба Нийлүүлэлтийн хуваарь бүхий үнийн саналыг саналын маягтын хамт 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 11 цаг 00 минутаас өмнө бусад шаардагдах бичиг баримтын хамт гарын үсэг зурж, доорх хаягаар ирүүлнэ.

Захиалагчийн хаяг:

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Төрийн өмчийн XI байр, 403 тоот
Утас: 70002140
Цахим хаяг: info@srs2.mn (зөвхөн тодруулга авах зорилгоор)

- (vii) Тендерийн нээлтийг 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 11 цаг 10 минутад дараах байршилд оролцох сонирхолтой нийлүүлэгчийн төлөөллийн хамт хийнэ.

Хаяг:

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Төрийн өмчийн XI байр, 403 тоот

Үнийн саналыг үнэлэх ба харьцуулалт

- (viii) Үнийн саналын хүсэлтийг үндсэнд нь хангаж буй саналуудыг цаашид үнийг нь харьцуулах замаар үнэлнэ. Тухайн санал нь том зөрүү агуулсан, эсвэл санал авах хүсэлтэд заасан нөхцөл, шаардлага, тодорхойлолтын хувьд болзолт нөхцөлийг шаардсан бол саналыг үндсэндээ шаардлагад нийцэхгүй гэж үзэж, түүнийг цаашид үнэлгээнд харгалзахгүй.
- (ix) Захиалагч саналуудыг үнэлэхдээ, арифметик алдааг дараах байдлаар залруулна:
 - (i) тоо болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрүүтэй байгаа бол үгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэх;
 - (ii) нэгж үнийг тоогоор үржүүлсэнтэй холбоотойгоор нэгж үнэ ба нийт үнийн хооронд зөрүүтэй бол нэгж үнийг баримтлах;Нийлүүлэгч залруулгыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал, түүний саналаас татгалзана.

Гэрээг байгуулах эрх олгох:

- (x) Захиалагч гэрээ байгуулах эрхийг Үнийн саналын хүсэлтийн дагуу бүх бараанд шаардлага хангаж, сайн үнэлэгдсэн хамгийн бага үнийг санал болгож байгаа нийлүүлэгч компанид олгоно.
- (xi) Захиалагч энэхүү санал авах хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 45 хоногийн дотор саналыг хүлээн зөвшөөрсөн нийлүүлэгчийн үнийн саналын маягтын хувийг буцааж авснаар, гэрээний эрх олгосон тухай мэдэгдэнэ.
- (xii) Шалгарсан нийлүүлэгч гэрээний маягт болон үнийн ба нийлүүлэлтийн нөхцөл, шаардлагад заасны дагуу гэрээнд гарын үсэг зурна. Санал болгосон үнэд Монгол улсад мөрдөж байгаа гааль, нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) болон бусад төрлийн татварыг оруулна.

5. Нэмэлт мэдээллийг дараах хаягаас авах боломжтой:

Захиалагчийн хаяг:

Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,
Төрийн өмчийн XI байр, 403 тоот
Утас: 70002140
Цахим хаяг: info@srsp2.mn

6. Захиалагч нь энэхүү Үнийн саналын хүсэлтийн дагуу хийгдсэн гэрээний хүрээнд хийгдэх эрх бүхий төлбөрт Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны эх үүсвэрээс санхүүжилтийг олгоно.

7. АХБ-ны авлигын эсрэг бодлогын дагуу, (1998 оноос одоог хүртэл нэмэлт өөрчлөлт оруулсан) нийлүүлэгч худалдан авах ажиллагаа болон түүнээс үүдэн гарах гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг сахина. Хэрэв гэрээний эрх авсан тендерт оролцогч эсвэл аливаа бусад этгээд тендерт өрсөлдөх эсвэл гэрээг хэрэгжүүлэх саад учруулах, гэрээний нөхцөлийг зөрчих үед, мөн авлигал, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах эсвэл дарамт шахалт үзүүлэх үйлдэлд оролцсон нь тогтоогдвол АХБ гэрээний эрх олгох саналаас татгалзаж, үүнд холбогдсон этгээдэд хориг тогтооно. Мөн үнийн саналаа ирүүлэх мөчид, та АХБ-ны хориг жагсаалтад ороогүй байвал зохино. Та/танай компани АХБ-наас Авлигын эсрэг бодлогын дагуу эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлсэн буюу хасагдсан, АХБ-

наас хориг арга хэмжээ авсан тохиолдолд шийдвэрийг харилцан биелүүлэх хэлэлцээрийн дагуу АХБ-ны санхүүжилттэй, захиран зарцуулдаг, эсвэл дэмжигддэг төслийн хүрээнд худалдан авалтын аливаа үйл ажиллагаанд оролцох эрхгүй.

8. Та/танай компани болон хамтарсан түншүүд, туслан гүйцэтгэгч, толгой болон салбар компани түүний туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчээр гэрээ ба гэрээний аль нэг хэсгийг гүйцэтгэж ажиллахдаа захиалагчийн улс, олон улсын байгууллага, бусад хандивлагчдын хориг жагсаалтад эрхийг нь түр хугацаагаар шаардлага хангаагүй буюу түдгэлзүүлсэн байх ёсгүй.

Хэрэв эрхийг түр хугацаагаар шаардлага хангаагүй буюу түдгэлзүүлсэн гэж хориг жагсаалтад орсон бол /хамтарсан түншүүд, туслан гүйцэтгэгч, толгой болон салбар компани түүний туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч бүрд хамааралтай бол/ дэлгэрэнгүй мэдээллийг доор бичнэ үү.¹

- a. Байгууллагын нэр: _____
- b. Эрхийг түр хугацаагаар шаардлага хангаагүй буюу түдгэлзүүлсэн гэж хориг жагсаалтад орсон хугацаа:/эхлэх ба дуусах огноо/

- c. Эрх нь түр хугацаагаар шаардлага хангаагүй буюу түдгэлзүүлсэн гэж хориг жагсаалтад орсон шалтгаан:

9. Та/танай компани болон хамтарсан түншүүд, туслан гүйцэтгэгч, толгой болон салбар компани түүний туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч компанийн захирал, удирдах албан тушаалтнууд нь хууль зөрчөөгүй /зөрчил гаргасан, захирамж зөрчсөн, эрүүгийн ба хүнд гэмт хэрэгт холбогдоогүй, яллагдагчаар татагдаагүй хорих ялаар шийтгэгдээгүй/ байх ёстой.

Хэрэв дээрх хэрэгт буруутгагдсан буюу хорих ялаар шийтгэгдсэн бол дэлгэрэнгүй мэдээллийг доор бичнэ үү.²

- a. Гэмт хэрэг/зөрчлийн зүйл анги: _____
- b. Харьяаллын нутаг дэвсгэрт орших шүүх байгууллага:

- c. Шийдвэр, тогтоол: /хэрэгсэхгүй болгосон, ял шийтгэл/хугацаа гэх мэт/:

- d. Холбогдох бусад дэлгэрэнгүй мэдээлэл: _____

10. Та/танай компани болон хамтарсан түншүүд, туслан гүйцэтгэгч, толгой болон салбар компани түүний туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчээр гэрээ ба гэрээний аль нэг хэсгийг гүйцэтгэж ажиллахдаа захиалагчийн улс, олон улсын байгууллага, бусад хандивлагчдын хориг жагсаалтад эрхийг түр хугацаагаар шаардлага хангаагүй буюу түдгэлзүүлсэн бол эсвэл компани болон хамтарсан түншүүд, туслан гүйцэтгэгч, толгой болон салбар компани түүний туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч компанийн захирал, удирдах албан тушаалтнууд хууль зөрчсөн/эсвэл зөрчил гаргасан, захирамж зөрчсөн, хорих ялаар шийтгэгдсэн бол АХБ-нд мэдэгдэх үүрэгтэй гэдгийг ойлгох ёстой бөгөөд мэдэгдээгүй тохиолдолд АХБ бусад олон талт хөгжлийн банкнууд, захиалагчийн улс, олон улсын байгууллага, бусад хандивлагчидтай хамтран ажиллуулахаас татгалзана.

11. АХБ-ны Авлигын эсрэг бодлого, (1998 оноос өнөөдрийг хүртэл нэмэлт өөрчлөлт оруулсан,) ба Шударга байдлын зарчим, удирдамжид (2015 он, үе үе нэмэлт, өөрчлөлт оруулсан) заасны дагуу санамсаргүйгээр буюу санаатайгаар буруу мэдээлэл өгч төөрөгдүүлсэн тохиолдолд үнийн санал/тендерээс шууд татгалзах, гэрээг цуцлахад хүргэж болзошгүй юм.

¹ Холбогдох мэдээллийг захиалагч АХБ-нд гаргаж өгнө.


² Холбогдох мэдээллийг захиалагч АХБ-нд гаргаж өгнө.

12. Тендерт оролцогч нь ашиг сонирхлын зөрчилгүй байх ёстой. Ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзсэн бүх тендерт оролцогчийг оролцуулах эрхийг хасна.

13. Та энэхүү хүсэлтийг авсан тухай болон үнийн санал ирүүлэх эсэхээ захиалагчийн цахим хаягаар мэдэгдэнэ үү.

Хүндэтгэсэн,

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ЭДИЙН
ЗАСАГ, САНХҮҮ, ТӨСӨВ, ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА



Ж.ЭНХТӨР

ҮНЭ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Татвар: Татварын дүнг тусад нь илэрхийлнэ.

Д/д	Барааны нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Татвар тооцоогүй нийт үнэ	Татварын дүн	Татвар тооцсон нийт үнэ	Хүргэлтийн хуваарь
1	Дотоод сүлжээний төхөөрөмжүүдийг хянах, сүлжээний ачааллыг зохицуулах программ хангамж	ширхэг	1					Гэрээ байгуулснаас хойш 30 хоног Бараа хүргэгдэх байршил: 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
2	Халамжийн нэгдсэн систем (ehalamj)-ийн хэрэглэгчид рүү автоматаар мэдэгдэл илгээх програм хангамж	жил	3					
3	Бизнесийн ухаалаг системийн программ хангамжийн лиценз	багц	1					
4	Microsoft 365 Business Standard эсхүл дүйцэх	багц	1					
5	Microsoft defender for endpoint эсхүл дүйцэх	багц	1					
6	Нийлүүлсэн барааг суулгах, тохируулах үед үзүүлэх техникийн дэмжлэг	өдөр	15					
Нийт			22					Бараа хүлээн авснаас хойш 15 хоног Байршил: 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлсэн программ хангамж, түүний лицензийг суулгаж, тохируулахад ямар нэгэн нэмэлт төлбөргүйгээр техникийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Хүний нөөцийн шаардлага: Танай байгууллага нийлүүлсэн программ хангамж, түүний лицензийг суулгаж, тохируулахад ямар нэгэн нэмэлт төлбөргүйгээр техникийн дэмжлэг үзүүлэх шаардлагатай тул танай байгууллага үүнийг гүйцэтгэх чадавхтайгаа харуулах үүднээс 5-аас доошгүй тооны үндсэн ажилтай байх ёстой. Үүнийг нийгмийн даатгалын шимтгэл төлдөг эсэхээр тодорхойлох бөгөөд 12 сараас доошгүй хугацаанд тухайн байгууллагын нэр дээр шимтгэл төлсөн байна. Шаардлага хангасан тооны үндсэн ажилтны нийгмийн даатгалын тодорхойлолтыг ирүүлнэ.

Д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Техникийн үзүүлэлт
1	Дотоод сүлжээний төхөөрөмжүүдийг хянах, сүлжээний ачааллыг зохицуулах программ хангамж	ширхэг	1	WhatsUp Gold Premium 750 New Devices эсхүл дүйцэх Perpetual license and support 1 year эсхүл дүйцэх
2	Халамжийн нэгдсэн систем (ehalamj)-ийн хэрэглэгчид рүү автоматаар мэдэгдэл илгээх програм хангамж	жил	3	Sendgrid Pro 300K эсхүл дүйцэх Send up to 300,000 emails/mo before overages apply. 1,000 teammates permission APIs, SMTP Relay, and Webhooks Delivery Optimization Tools Dynamic Templates + Testing Insightful Analytics Guaranteed Response Times on Ticket, Chat, & Phone Support Deliverability Insights 2,500 Email Validations Dedicated IP Included Subuser Management Single Sign-On (SSO) 3 years license
3	Бизнесийн ухаалаг системийн программ хангамжийн лиценз	багц	1	Equivalent to Tableau Creator (Includes: Tableau Desktop, Tableau Prep Builder, and one Creator license of Tableau Server эсхүл дүйцэх) or up Хугацаа: 3 жил Лицензийн тоо:5 Equivalent to Tableau Viewer (Includes: One Viewer license of Tableau Server эсхүл дүйцэх) or up Хугацаа : 3 жил Лицензийн тоо: 13 Support 1 year
4	Microsoft 365 Business Standard эсхүл дүйцэх	багц	1	Equivalent to Microsoft 365 Business Standard or up: Desktop versions of Word, Excel, PowerPoint, and Outlook эсхүл дүйцэх Webinars with attendee registration and reporting

Д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Техникийн үзүүлэлт
				Collaborative workspaces to co-create using Microsoft Loop эсхүл дүйцэх Video editing and design tools with Microsoft Clipchamp эсхүл дүйцэх Microsoft 365 Copilot , available as an add-on3 Desktop, web, and mobile apps and secure cloud services: Word, Excel, Powerpoint, Outlook, Teams, Onedrive, Sharepoint, Exchange, Clipchamp, Microsoft Loop эсхүл дүйцэх 150 Хэрэглэгч 12 сарын хугацаатай
5	Microsoft defender for endpoint эсхүл дүйцэх	багц	1	Equivalent to Microsoft defender for endpoint or up: Antivirus and anti-phishing protection for 1 person, up to 5 devices at the same time Continuous monitoring for device threats Multidevice alerts Security tips and recommendations 150 Хэрэглэгч 12 сарын хугацаатай
Нийт			7	

САНАЛЫН МАЯГТ

Хэнд: _____ (Захиалагчийн нэр)

_____ (Захиалагчийн хаяг)

Бид _____ (гэрээний нэр ба дугаар)-г гэрээний хугацаа нөхцөл, нийлүүлэлтийн хуваарийн дагуу _____ (үнийн дүнг үсэг ба тоогоор илэрхийлэх) _____ (мөнгөн тэмдэгтийн нэр) гэрээний үнийн энэхүү саналын дагуу хэрэгжүүлэхээр санал болгож байна. Бид гэрээнд дурдсан барааг гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш үнэ ба нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэлтийн хугацаанд багтаан хүргэж дуусгах саналтай байна.

Энэ санал болон таны бичгээр үйлдсэн зөвшөөрөл нь бидний хооронд байгуулах гэрээний салшгүй хэсэг байх болно. Хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер болон бусад хүлээн авсан тендерийг та хүлээн зөвшөөрөх үүрэг хүлээгээгүй гэдгийг бид ойлгож байна.

Энэ санал нь санал авах хүсэлтийн баримт, нийлүүлэлтийн нөхцөл шаардлагад тус тус заасан саналын хүчинтэй хугацаа ба баталгаат хугацааны нөхцөлд нийцэж байгааг бид үүгээр баталгаажуулж байна.

Бид (а) АХБ-ны гишүүн орны харьяалалтай; (б) энэхүү санал авах хүсэлттэй уялдсан гэрээний зураг төсөл, тодорхойлолтыг бэлтгэсэн компанитай хамтран оролцоогүй; (в) Захиалагчийн өмчлөлд хамааралгүй; (д) одоогоор Азийн хөгжлийн банкны эрхийг түр хугацаагаар шаардлага хангаагүй буюу түдгэлзүүлсэн гэж хориг жагсаалтад ороогүй; (д) НҮБ-ын дүрмийн 7-р бүлэгт заасан НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийн дагуу танай улсаас бараа, үйлчилгээ импортлох, танай улсад байгаа этгээд, аж ахуйн нэгжид аливаа төлбөр төлөхийг хориглоогүй болно.

Нийлүүлэгчийн нэр: _____

Эрх бүхий гарын үсэг: _____

Гарын үсэг зурсан этгээдийн нэр: _____

Гарын үсэг зурсан этгээдийн албан тушаал _____

Хаяг: _____

Утасны дугаар: _____

Факсын дугаар, шаардлагатай бол: _____

Цахим шуудан хаяг (шаардлагатай бол): _____

ХҮЛЭЭН АВАХ

Захиалагч нь нийлүүлэгчийн санал, барааг нийлүүлэх хүргэх нөхцөлийг үүгээр хүлээн зөвшөөрсөн. Хавсаргасан гэрээ, гэрээний үнийг нийлүүлэгч хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж, маягтыг баталгаажуулан Захиалагчид 15 хоногийн дотор хүргүүлнэ.

Захиалагчийн нэр: _____

Эрх бүхий гарын үсэг: _____

Гарын үсэг зурсан этгээдийн нэр: _____

Гарын үсэг зурсан этгээдийн албан тушаал _____

Огноо: _____

ГЭРЭЭ

Захиалагчийн Улсын нэр: Монгол Улс

Төслийн нэр: Зээл 4052-MON: Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2

Гэрээний нэр: Программ хангамжийн лиценз нийлүүлэх

Гэрээний дугаар: G002

Энэхүү гэрээг 2024 оны 12 дугаар сарын -ний өдөр нэг талаас Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (цаашид "захиалагч" гэх) болон нөгөө талаас "....." ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) нар байгуулав.

Захиалагч G002: Программ хангамжийн лиценз нийлүүлэх тендер (цаашид "гэрээ" гэх)-ийн дагуу нийлүүлэгчээс программ хангамжийн лиценз (барааны нэр) нийлүүлэх саналыг хүссэн ба энэхүү гэрээний хүрээнд () төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх), нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв.

Захиалагч болон Нийлүүлэгч дараах зүйлсийг харилцан зөвшөөрөв:

1. Дараах бичиг баримтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно:

- a) Саналын маягт; нийлүүлэлтийн хуваарь
- b) Гэрээний нөхцөл шаардлага,
- c) Техникийн тодорхойлолт;

2. Цаашид дурдсаны дагуу захиалагчаас нийлүүлэгчид хийх төлбөрийг үндэслэн, нийлүүлэгч нь энэ гэрээний хүрээнд барааг нийлүүлэх үүргийг гүйцэтгэж дуусгах, энэхүү гэрээний бүх нөхцөлд нийцүүлэн аливаа гэмтэл согог арилгах зорилгоор захиалагчтай энэхүү гэрээг үүгээр байгуулав.

3. Захиалагч нь гэрээг хүлээн зөвшөөрсөн байдал, барааг нийлүүлж хүргэх нөхцөл, болон гэмтэл согог арилгах үйлчилгээ зэргийг үндэслэн гэрээний үнийг гэрээнд тодорхойлсон төлбөрийн нөхцөлийн дагуу төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

Талууд энэхүү гэрээг Монгол Улсын хуулийн хүрээнд дээр дурдсан өдөр үүгээр байгуулав.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал, нэр,
гарын үсэг:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Албан тушаал, нэр,
гарын үсэг:

тамга

Захиалагчийн хаяг:

тамга

Нийлүүлэгчийн хаяг:

ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Төслийн нэр: Зээл 4052-MON: Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2
Захиалагч: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
Гэрээний нэр, дугаар: G002: Программ хангамжийн лиценз нийлүүлэх

1. Тодорхойлолтууд:

- a) "Гэрээ" гэж үүнд дурдсан бүх баримт бичиг, хавсралт, хавсарга бүхий бүх баримт бичгийг агуулсан захиалагч нийлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээг хэлнэ.
- b) "Гэрээний баримт бичиг" гэж гэрээнд оруулсан бүх бичиг баримт түүний аливаа нэмэлт, өөрчлөлтийг агуулсан баримт бичгийг хэлнэ.
- c) "Гэрээний үнэ" гэж гэрээнд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт болон татварын хасалт хийсэн тохиолдолд нийлүүлэгчид төлөх төлбөрийг хэлнэ.
- d) "Хүргэлт" гэж гэрээнд заасан нөхцөл, шаардлагын дагуу бараа нийлүүлэгчээс захиалагчид хүлээлгэн өгөхийг хэлнэ.
- e) "Гүйцэтгэл" гэж гэрээнд заасан нөхцөл, шаардлагын дагуу нийлүүлэгчээс хүргэлт болон холбогдох аливаа үйлчилгээг биелүүлэхийг хэлнэ.
- f) "Бараа" гэж гэрээний дагуу нийлүүлэгчээс захиалагчид нийлүүлэх шаардлагатай бүх бараа бүтээгдэхүүн, түүхий эд, машин тоног төхөөрөмж/эсвэл бусад материал/хэрэгслийг хэлнэ.
- g) "Захиалагч" гэж гэрээнд заасан нөхцөлөөр бараа, холбогдох үйлчилгээг худалдан авч буй байгууллагыг хэлнэ.
- h) "Нийлүүлэгч" гэж гэрээ байгуулах саналыг захиалагч хууль ёсоор хүлээн зөвшөөрсөн этгээд бөгөөд уг гэрээний дагуу хувь хүн, хувийн болон төрийн байгууллага, эсвэл дээр дурдсан хослолын төлөөллийг хэлнэ.
- i) "АХБ" нь Азийн хөгжлийн банк юм.

2. Мөрдөх хууль:

2.1 Гэрээг захиалагчийн улсын хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

3. Хэл:

3.1 Гэрээтэй холбоотой бүх харилцаа холбоо, баримт бичиг нь монгол хэл дээр байна.

4. Даалгавар:

4.1 Захиалагчийн урьдчилж бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэхүү Гэрээний бусад үүрэг, эсхүл аливаа эрхийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүйд тооцно.

5. Авлига болон залилан:

5.1 Энэхүү гэрээг Авлигын эсрэг бодлого, (1998 оноос өнөөдрийг хүртэл нэмэлт өөрчлөлт оруулсан), Шударга байдлын зарчим, удирдамж (2015, үе үе нэмэлт, өөрчлөлт оруулах) - ийн дагуу зээлдэгчээс (АХБ-ны санхүүжилттэй төслийн үр шимийг хүртэгчдийг оролцуулан) АХБ-ны санхүүжилттэй гэрээний дагуу нийлүүлэгчид болон гүйцэтгэгчид эдгээр гэрээг худалдан авах, гүйцэтгэх явцад хамгийн өндөр ёс зүйн хэм хэмжээг сахихыг шаардана.

6. Гэрээний тогтмол үнэ:

6.1 Саналын маягтад заасан үнэ нь тогтмол байх ба гэрээний хэрэгжилтийн явцад ямар нэгэн залруулга өөрчлөлт хийхгүй.

7. Хүргэлтийн хуваарь:

7.1 Нийлүүлэлтийг дээрх хуваарийн дагуу хийж гүйцэтгэх ёстой боловч гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс 45 хоноогоос хэтрэхгүй хугацаанд хийж дуусгана.

8. Шаардлагатай техникийн тодорхойлолт: (шаардлагатай бол хавсралтаар гаргаж бэлтгэх)

- (i) Ерөнхий тойм
 - (ii) Онцлог нарийн болон техникийн жишиг үзүүлэлтүүд
 - (iii) Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд
- Нийлүүлэгч дээр дурдсан үзүүлэлтүүдэд нийцэж байгааг үүгээр баталж байна.

9. Хүргэлт болон бүрдүүлэх баримт бичиг:

9.1 Нийлүүлэгч нь барааг нийлүүлэхдээ дараах баримтуудыг захиалагчид гаргаж өгнө:

- (i) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж үнэ болон нийт үнийг заасан нэхэмжлэлийн хуулбар;
- (ii) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; ба
- (iii) Гарал үүслийн гэрчилгээ

Хэрвээ барааг буухиа шуудангаар илгээх тохиолдолд барааг хүлээн авах захиалагчийн нөхцөлийг хангах үүднээс нийлүүлэгч баримтуудын хуулбарыг бараа нийлүүлэхээс өмнө гаргаж өгнө. Захиалагч дээрх баримтуудыг бараа ирэх өдрөөс 1-ээс доошгүй 7 хоногийн өмнө хүлээн авсан байна. Хэрэв баримтыг хүлээн аваагүй бол нийлүүлэгч үүнтэй уялдан гарах аливаа зардлыг хариуцна.

10. Татвар, хураамж:

10.1 Нийлүүлэгч нь гэрээт барааг захиалагчид хүргэхэд гарах бүх татвар, хураамж, лицензийн төлбөр гэх мэт бүх зардлыг бүрэн хариуцна.

11. Төлбөр:

11.1 Гэрээний үнийн төлбөрийг дараах нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ:

- а) Нийлүүлсэн барааг захиалагч шалгаж хүлээн зөвшөөрч, хүлээн авсан тохиолдолд 100 хувь. Бараа хүлээн авсан акт болон 9 дүгээр зүйлд заасан баримт бичгийг үндэслэн нийлүүлэгчийн төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор хийнэ.

12. Баталгаат хугацаа:

12.1 Санал болгож буй барааг Захиалагчид хүргүүлсэн өдрөөс хойш дор хаяж 12 сарын хугацаанд үйлдвэрлэгчийн баталгаанд хамруулах ёстой.

13. Гэмтэл согог:

13.1 Нийлүүлэгч бүх гэмтэл согогийг захиалагчаас мэдэгдэл авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор захиалагчаас ямар ч зардал гаргахгүйгээр засварлана. Баталгаат хугацаанд нийлүүлэгчээс гэмтэл согогийг засварлах газрын нэр хаяг:

Байгууллага: _____

Хаяг: _____

14. Маргаан шийдвэрлэх:

14.1 Захиалагч болон нийлүүлэгч нь тэдгээрийн хооронд гэрээтэй холбогдон гарч болох аливаа үл тохиролцол эсвэл маргааныг албан бус, шууд хэлэлцээрээр зөвшилцөн шийдэхийг хичээнэ. Захиалагч ба нийлүүлэгчийн хооронд маргаан үүссэн тохиолдолд, уг маргааныг Монгол улсын арбитрын хууль дүрмийн заалтын дагуу шийдвэрлэнэ.

15. Гэрээг гүйцэтгэхгүй байх:

15.1 Нийлүүлэгч дээр дурдсан нөхцөл шаардлагын дагуу барааг хүргэж чадаагүй тохиолдолд захиалагч 14 өдрийн дотор мэдэгдэл хүргэхгүйгээр, нийлүүлэгчид аливаа үүрэг хариуцлага ногдуулахгүйгээр гэрээг цуцалж болно.

16. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл:

16.1 Хэрэв гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний хүрээнд ажлын гүйцэтгэл удааширсан эсхүл гэрээний үүргийг биелүүлэх явцад аливаа алдаа гарсан тохиолдолд нийлүүлэгч торгууль эсхүл гэрээг цуцалсан асуудлыг хариуцахгүй.

- а) Энэ зүйлийг тодруулах зорилгоор, “гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл” гэдэг нь нийлүүлэгчийн хяналтаас гадуур, бөгөөд нийлүүлэгчийн алдаа эсхүл хайхрамжгүй

байдлаас ангид, ба урьдчилан харах боломжгүй үйл явдлыг хэлнэ. Ийм үйл явдалд дайн, эсвэл хувьсгал, гал түймэр, үер, халдварт өвчин, хорио цээр, ба ачаа тээврийн хориг орж болох бөгөөд энэ нь нийлүүлэгчийн бие даасан чадамжийн хүрээнд түүний үйлдлээр хязгаарлагдахгүй болно.

- b) Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайж олно.

17. Шударга байдлыг зөрчсөний улмаас гэрээг цуцлах:

- 17.1 Нийлүүлэгч энэхүү гэрээг байгуулахын тулд тендерт өрсөлдөх буюу гүйцэтгэхэд гэрээний нөхцөлийн 5-р зүйлд заасан [Авлига ба залилан] зөрчлийг гаргасан бол захиалагч гэрээг бүхэлд нь буюу хэсэгчлэн цуцалж болно.

18. Данс бүртгэл:

- 18.1 Нийлүүлэгч нь энэхүү гэрээ хэрэгжиж дууссан буюу цуцлагдсанаас хойш 3-аас доошгүй жилийн хугацаатай тухайн салбарт хэрэглэдэг маягтын дагуу нийлүүлсэн барааны талаар дэлгэрэнгүйгээр үнэн зөв, системтэй данс бүртгэл хөтөлнө.

19. АХБ-аас зээл буюу төлбөрийг хойшлуулах:

- 19.1 АХБ-аас захиалагчид өгөх зээл, зээлийн төлбөрийг хойшлуулсан үед нийлүүлэгчид төлөх төлбөрийн тодорхой хэсгийг өгөх тохиолдолд:

- a) Захиалагч нь АХБ-ны хойшлуулсан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор энэ тухай мэдэгдлийн хуулбарыг нийлүүлэгчид хүргүүлэх үүрэгтэй.
- b) Хэрэв нийлүүлэгч 11-р зүйлд [Төлбөр] заасан төлбөрийг 28 хоногийн дотор хүлээн аваагүй бол нийлүүлэгчээс 14 хоногийн хугацаанд цуцлах тухай мэдэгдэнэ.